

## Ургац хураах үеэр

*(Гэрэл зурагт тэмдэглэл)*

Зөөлөн салхи үл мэдэг үлээсэн намрын шар нар таатайяа халаасан нэг өдөр Зуунмод голын баруун эрэгт байгаа төвийн 10 жилийн дунд сургуулийн хөдөлмөр амралтын зуслангийн «Авдархангай» нэгдлээс хариуцан авсан хүнсний ногооны 11,5 га газарт хүүхэд багачуудын хөгжөөнт дуу цуурайтаж, олон хүүхэд хөдөлмөрлөж байгааг харахад үнэхээр бахтай байлаа. Энэ бол хөдөлмөр амралтын зусланд амрагсад энэ талбайд идэшний таван төрлийн ногоо тариад одоо ургацаа хураaж байгаа нь энэ ажээ.

Зусланд ажилласан 8а, 9а, 9б ангиудын 90 гаруй сурагчид үр суулгах, зэрлэг, зулгаах, хөрсийг сийрүүлэх, ургацаа хурааж хадгалах хүртэл идэшний ногооны агротехникийн шаардлагыг мэддэг болсон ба үнээ, гүү, ямаа саaж айраг исгэж, цагаан идээ хийж сурсан байна. Мөн эрэгтэй чүүд нь адуу маллах, манах ажилд дадлагажижээ. Хөдөлмөр амралтын зусланд ингэж ажиллаад сурагчид өөрсдөө их зүйлийг сурч мэдээд, заалгасан хичээлээ бататгаад зогссогүй нэгдэлдээ төмс, байцаа, манжин 90—ээд тонныг хураан авч тушаасан ба тооцоолж үзвэл нэгдэлд 100 гаруй мянган төгрөгийн ашиг оруулж тусалсан байна.



ЗУРАГ ДЭЭР;
—Байцааны чинь энэ их далбайсан навч хэрэггүй байдаг юм байгаа биз дээ, тас цавчаад ногоонд хаячих уу? гэж нэг нь асуухад:
—Хаанаас! Овоолж аваад сургууль малаа тэжээхгүй юу гэж нэг нь зөвлөжээ.



ЗУРАГ ДЭЭР:
—Багшаа нэг бутнаас 20—25 том төмс гарах юм. Нэг төмс л ийм олон болдог юм уу? гэж сурагчид нь асуухад багш Баяртогтох учрыг нь тайлбарлаж байна.



ЗУРАГДЭЭР: 7г ангийн Ж.Гомбожавын бригад ургац хураах ажилд гологдохгүй сайн ажиллажээ. Ер нь ажил бүхэнд хушуучилдаг бригад шүү.

*Д.Давдай*

## Өндөр ургац даллаж байна

### ТОВЧХОН МЭДЭЭ

Баянцагаан сумын «Өрнөх амьдрал» нэгдэл малдаа тэжээлийн нөөцтэй болж хүн амаа хүнсний ногоогоор хангах зорилгоор 1963 оноос эхлэн газар тариалангийн ажил эрхлэн явуулж энэ жил 300 гаруй тонн үр тариа, 80 тонн идэшний ногоо хурааж 1 га-гаас улаан буудай, овъёос 10-12 центнер, идэшний ногоо 10-12 тонныг хураан авч, сонгино, байцаа, манжин, лууван, төмс зэрэг идэшний ногоонуудыг нэгдлийн мухлагт борлуулж байна.

Түүнчлэн үрийн ногоо хадгалдаг галладаггүй нүхэн зоорь шинээр барьж ашиглалтанд оруулав. Тус сум—нэгдлийн тариалангийн талбайг улам өргөтгөн хөгжүүлэхээр Сэргэлэн сумын МААМС-ын Рэвдан даргатай бригад тариаг нь хурааж дуусаад атар ба зөөлөн хагалгаа хөрс боловсруулах ажлыг амжилттай хийж байна.

*Сүхбаатар*

❊ Өндөрширээт сумын бага сургуулийн 40 гаруй пионер сурагч «Хөгжлийн зам» нэгдлийн төмс хураах ажилд туслалцан амралтын нэг өдөр 2 га газраас 20 шахам тонн төмс хураав.

*Галсанжамц*

## Намрын ажил нааштай

Галт бадрахын нуруунд ган болж байгаагүй, тосон Заамрын ууланд зуд болж байгаагүй юм гэж ярьдаг. Заамар сум-нэгдлийн энэ нутгаар өнөө жил зуншлага сайтай байсан тул мал нь тарган, хүмүүс нь тохитой намаржиж байгаагийн дээр төлөвлөгөөт ажлын биелэлт урагштай явагдаж байна. Тус нэгдлийн хөдөлмөрчид одоогийн байдлаар тарваганы арьс ба техникийн тосны төлөвлөгөөг 101—117 хувиар биелүүлжээ. Анчин Намсрай, Бадрах нар гэрээгээ 102—103 хувиар биелүүлж тушаасан бүх арьсныхаа ихэнхийг нэгдүгээр зэрэгт нийлүүлсэн байна.

Сүү тушаалт, ахрын ноосны төлөвлөгөөг тус бүр 90 гаруй хувиар биелүүлээд байгаа нь ойрын хугацаанд төлөвлөгөөгөө давуулах боломжтой байна.

Үнээний сүү тушаалтын ажилд Элший, Жавзанпагма ахлагчтай социалист хөдөлмөрийн бригадын саальчин гишүүд идэвхтэй ажиллагаагаараа бусад саальчдаас түрүүлж явна. Ялангуяа социалист хөдөлмөрийн бригадын гишүүн, МХЗЭ-ийн гишүүн Дэлгэр, Дуламсүрэн нар хариуцсан үнээ бүрээсээ 15 хоногт 50-57 литр сүү саaж байгаа тул сар дутам нэгдлийн ерөнхий хорооны болзол хангаж байна.

Малдаа сайн чанарын тэжээл бэлтгэх ажлыг нэгдлийн намын үүр, сумын гүйцэтгэх захиргаа зохион байгуулж хадлангийн ажил амжилттай явагдаж 7500 тонн өвсний төлөвлөгөөг биелүүлж байна.

Заамар нэгдэл тариа тарьсан анхны жилээсээ эхлэн жил дараалан өндөр ургац авч байгаа бөгөөд энэ жил ч мөн арвин ургац авч байна.

Тариа хураалтын ажилд Эрдэнэсантын МААИС—ын комбайнч Түдэвжанцан, Цэдэн-иш, Магнай нар бусдаасаа сайн ажиллаж нэгдлийн ерөнхий хорооны болзлыг удаа дараа хангасан байна.

Тус сум-нэгдэл 1964 онд хонь 20670, ямаа 5296-г хээлтүүлэгт оруулахаас хээлтүүлгийн 3 функет 9 дүгээр сарын 10-наас эхлэн ажиллаж 2400 хонинд зохиомол хээлтүүлэг хийгээд байна.

Сумын намын үүр, гүйцэтгэх захиргаа, намын ажлын явцыг чанаржуулан сайжруулах ба өвлийн бэлтгэлийг хангах мөн хөдөлмөр зохион байгуулалтын ажлыг сайжруулах зэрэг асуудлыг авч хэлэлцээд тодорхой төлөвлөгөөтэй ажиллаж байна.

*Ж. Мөнхтогоо*

**НАМАР**

**МАНАЙ АЙМАГ ТАРВАГАНЫ АРЬСНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ 100,2 ХУВИАР БИЕЛҮҮЛЛЭЭ.**

